"Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт,
менежмент ҮЦК" ХХК-ийн 2025 оны 12 сарын 03-ны
өдрийн 123 тоот албан бичгийн хавсралт

# "НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**2025.12.03**

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1: Санхүү төсвийн зохицуулалт / ЗГҮАХ-3.1, НХТЖҮЧ-4.1.2/** | | | | | | | | |
| **Зорилт 1. Нийслэлийн төсвийн бус санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 1.1 | Нийслэлийг хөгжүүлэх сан болон бусад санг үүсгэн байгуулахтай холбоотой хууль эрх зүйн орчныг судлах, бүрдүүлэх, холбогдох журмыг боловсруулж батлуулах. | - | Сан үүсгэн байгуулах бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь | | 50 | 1. "Нийслэлийн Ногоон Сан Хувийн ХОС ТЗК" ХХК-г байгуулан удирдаж байгаа бөгөөд Улаанбаатар хотод хэрэгжих орон сууцны төслүүдийн хөрөнгө оруулалтыг тус сангаар дамжуулан хэрэгжүүлэхээр НОСК болон УБ түншлэл төвүүдтэй харилцан зөвшилцөж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн схемийг гаргаад байна.<br><br>2. "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц сан"-г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02/07 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц сан"-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн "Багц журам батлах тухай" 01/03 дугаар | 100% | 100% |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | тогтоолоор “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан хувийн ХОС” ХХК-ийн “Дотоод хяналтын журам”, “Нэгж эрх эзэмшигчдийг бүртгэх журам”, “Орлогыг сангийн активт бүртгэх журам”, “Зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам”, “Орлого болон ногдол ашиг хуваарилах журам”, “Эрсдэлийн удирдлагын журам”, “Санг татан буулгах журам”, “Ёс зүйн дүрэм ба мэргэжлийн үйл ажиллагааны стандарт”, “Сангийн хөрөнгөөр барьцаалан зээл авах журам”, “Гишүүдийн хурал зарлан хуралдуулах журам”-ыг тус тус баталсан. Энэ хүрээнд "Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК болон “Ди Би Эм ассет менежмент” ХХК хооронд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ хийгдсэн. Тус төслийн II бүрэлдэхүүн болох 4200 айлын ногоон орон сууцыг Баянхошуу дэд төвд 2354, Шархад дэд төвд 1846 орон сууцыг төлөвлөсөн. Дээрхи дэд төвүүдийн хүн амын нягтрал 370-462 хүн/га байхаар төлөвлөгдсөн нь иргэдийн амьдрах орчинд чухал нөлөө үзүүлж, түгжрэл, агаар орчны бохирдлыг бууруулах гол ач холбогдолтой. 2026 онд Сангийн яамнаас эхний санхүүжилт хийгдэхээр төлөвлөж, бодлогын бичиг баримтыг | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | СЗХ-д бүртгүүлэх, багц журам, үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсөв батлах зэрэг ажлууд хийгдэж байна.<br>(3) Нийслэлийн батлан даалтын сан үүсгэн байгуулах бизнес эдийн засгийн урьдчилсан судалгааг хийсэн бөгөөд дараах хууль эрх зүйн судалгааны нөхцөл байдлаас шалтгаалан Батлан даалтын санг байгуулах ажлыг зогсоосон болно. Үүнд (i) Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн “*4.1.Зээлийн батлан даалтын сан /цаашид “Сан” гэх/ нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.*” гэсэн заалт нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн “*4.1.1.“хөрөнгө оруулалтын сан” гэж хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах санг;*” хэлнэ гэсэн агуулгатай зөрчилдэж байгаа болно. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | “Нийслэлийн хөгжлийн сан”, “Нийслэлийн ногоон сан”, “Гарааны бизнесийг хөгжүүлэх сан”, “Эрсдэлийн удирдлагын сан”-гийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх | Сая төгрөг | Сангуудад татан төвлөрүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ | 3,400 | 304,000 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Хөрөнгө гаргах тухай" А/762 дугаар тогтоолоор 300,000,000,000 (гурван зуун тэрбум) төгрөгийг "Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК ХХК-ийн нэгж эрхийн хөрөнгө оруулалт" зардлаас гаргахыг захирамжилсан бөгөөд "Нийслэлийн хөгжлийн сан Хувийн ХОС ТЗК" ХХК-ийн Нэгж эрх эзэмшигчдийн 2024 оны 03/01 дугаар тогтоолоор 300,000,000,000 (гурван зуун тэрбум) төгрөгийг 14.44% хүүтэй "Цэцэнс майнинг энд Энержи" ХХК-ийн гаргаж буй бондод хөрөнгө оруулалсан бөгөөд уг төсөл одоогоор II блокын ажлыг эхлүүлэн үйл ажиллагаа явуулж байна. 2025 оны 11-р сарын 13-ны өдөр Эрчим хүчний зохицуулах хорооноос 2-р блокыг эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг өгч 2025/11/13-ны өдрөөс 2-р блокын арилжааны ажиллагаа эхлэн бүрэн хүчин чадлаар ажиллаж эхэлсэн. 2025.11.30- ны өдрөөр нийт үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч – 985.0 сая кВт.ц, нийт борлуулсан эрчим хүч – 892.0 сая кВт.ц байна.<br><br>1. “Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан”-д нийслэлийн төсвөөс 3,000,000,000 /гурван тэрбум/ төгрөгийг татан төвлөрүүлэх ажлын хүрээнд “НЭУС”-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхээр дүрмийн өөрчлөлтийг 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан болно.<br>2. Нийслэлийн Засаг даргын 2025 | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/956 дугаар захирамжийг гаргуулсан.<br><br>Сангийн дүрмийн санг 3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх хөрөнгө нь Засаг даргын дээрх захирамжийн дагуу Нийслэлийн өмчийн харилцааны газраар дамжуулан сангийн дүрмийн хөрөнгийг нэмэгдүүлэх зохицуулалттай. Одоогоор Нийслэлийн ЗДТГ-ын Төрийн сангаас Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тус хөрөнгийг шилжүүлээгүй байгаа бөгөөд Сангийн яам гүйлгээний эрх нээгээгүй байна гэх тайлбарыг өгөөд байна. | | |
| 1.3 | Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах | - | Үнэт цаас гаргах ажлын хэрэгжилтийн хувь | 50 | 100 | 1. Метро, трамвай зэрэг нийслэлд хэрэгжүүлэхээр зорьж байгаа 24 мега төслийн хөрөнгө оруулалт татахаар Олон Улсын хөрөнгө оруулалтын сан болон банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж хөрөнгө оруулалт хийхээр яригдаж байгаа ч Монгол Улсын Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын өрийн тааз зэрэг Монгол Улсын дотоод эрх зүйн байдлаас шалтгаалан хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа хойшлоод байна. | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | НЗД-ын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/785 тоот захирамжийн дагуу “НӨУБХОМ ҮЦК” ХХК нь Метро төслийн санхүүгийн зөвлөхөөр ажиллаж, төслийн санхүүжилтийн схемийг боловсруулсан. Төслийн батлан даагчаар ИБУИНХУ-ын Засгийн газрын UKEF байгууллага томилогдсон. Метроны төслийн санхүүгийн зөвлөх банкны сонгон шалгаруулалт хийгдэж, MUFG, JP Morgan, Standard Chartered, BNP Paribas зэрэг банкуудын саналыг судлан JP Morgan банкыг шалгаруулсан.<br>Төслийн ерөнхий координатор, АНУ-ын JP Morgan Chase Bank ажиллаж байна.<br><br>2. "Нийслэлийн Ногоон Сан" нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Хангарьд цогцолборын С блок буюу Green Office-ийн нийт хөрөнгө оруулалтыг арилжааны банкны эх үүсвэртэйгээр бүрдүүлэхээр НЗДТГ-тай хамтран хэлэлцээрийн шатандаа явж байна.<br><br>Үнэт цаас гаргахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах хүрээнд аудит, зээлжих эрхийн зэрэглэл тогтоох, андеррайтерын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | дараах уулзалтуудыг зохион байгуулсан.<br>1. Олон Улсын аудит, хөрөнгийн үнэлгээ, бусад санхүүгийн болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр:<br>Олон Улсын аудитын байгууллагаар нийслэлийн хөрөнгийг үнэлүүлэх, гадаад улсад үнэт цаас гаргах, аудитын зөвлөгөө авахтай холбоотойгоор 2025 оны 1-3 дугаар саруудад Улаанбаатар хотод байрлах EY (Ернест Янг аудит - БНХАУ-д байдаг салбарт харьяалагддаг), PwC (ПиДабльюСи Аудит - Бүгд Найрамдах Солонгос улсад харьяалагддаг), KPMG (КэйПиЭмЖи Аудит -Казакстан улсын салбарт харьяалагддаг) зэрэг аудитын байгууллагуудтай уулзаж зах зээлийн дүн шинжилгээ хийсэн.<br>2. Үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотой зээлжих эрхийн зэрэглэл тогтоох байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:<br>Олон Улсын зээлжих эрхийг тогтоодог Fitch байгууллагатай ажил хэргийн цахим уулзалтыг 2025 оны 06 дугаар сард, биечилсэн уулзалтыг 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | Үнэт цаас гаргахтай холбоотой зээлжих эрх олгох тус байгууллагын хамтран ажиллах болон үнийн саналыг 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдөр авсан.<br>Fitch байгууллага нь S&P болон Moody's байгууллагаас харьцангуй бага үйлчилгээний төлбөрийг Монгол Улсын үйлчлүүлэгчидэд санал болгодог. Цаашид Нийслэл улаанбаатар хот Fitch-ийн үнэлгээ хийлгэх тохиолдолд НӨУБХОМ ҮЦК ХХК-ийн зээлжих эрхийн үнэлгээг илүү хөнгөлттэй үнээр хийлгэх боломж бий болсон.<br>3. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтын ажиллагаа:<br>Korea Investment & Securities Asia Limited компани нь Монгол Улсын Голомт банкны 300 сая ам долларын 3 жилийн хугацаатай, Монголын Ипотекийн Корпорацийн 225 сая ам. долларын 3 жилийн хугацаатай бондыг амжилттай гаргахад оролцсон компани юм.<br>Тус компанитай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр үзүүлэх үйлчилгээний цар хүрээ болон үнийн саналыг авсан.<br>Цаашид аудит дүн шинжилгээ, зээлжих зэрэглэл, андеррайтер сонгон | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | шалгаруулалт дууссанаар үнэт цаас гаргах хууль, зах зээлийн бэлтгэл, төлбөр тооцоо, мэдээллийн ил тод байдлыг хангах төлөвлөгөөг 2026 онд боловсруулах, батлуулахаар төлөвлөсөн. Гадаад бонд гаргах төслүүдэд санал авч хууль эрх зүйн орчныг судлан, Төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2:** Дулаан цахилгаан хангамж, мэдээлэл холбоо /ЗГҮАХ-1.3.4, НХТЖҮЧ-9.12.1/ | | | | | | | | |
| **Зорилт 2.** Цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 2.1 | Бөөрөлжүүтийн хүрэн нүүрсний ордыг түшиглэсэн 300 мВт-ын хүчин чадал бүхий дулааны цахилгаан станцыг барьж байгуулах ажилд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих | Төр хувийн хэвшлийн түншлэл | Хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | Монгол Улсын Засгийн газрын "Нийслэлийн дотоод үнэт цаас гаргах тухай" 201 дугаар тогтоолоор Бөөрөлжүүтийн цахилгаан станцад 300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид даалгасан.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 мВт-ын эхний блокын барилга угсралтын ажил 2024 оны 12 сард бүрэн дуусч, 2025 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс Төвийн эрчим хүчний системд цахилгаан нийлүүлж, 2-р блокийн ЦС-ын барилга угсралтын ажил 43%, Барилгын ажил 62%, зуухны угсралтын ажил 66%-тай | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хяналсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | явагдаж байсан бөгөөд бүтээн байгуулалтын төслийн тооцооллын дагуу улирал тутам эргэн төлөлт хийгдэж, төслийн үйл явц, үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан.<br>2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар II блокын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл болон тээвэрлэлт 100% бүрэн хийгдсэн.<br>1. Бөөрөлжүүт цахилгаан станцын төслийн 2-р блокын хүрээнд 10 дугаар сарын 2-ны өдөр Техникийн комисс амжилттай ажиллав. 10 дугаар сарын 8-ны өдөр үүрэг даалгаврын биелэлтийг хангаж Техникийн комиссын дүгнэлтийг гардан авсан.<br>2. 2025 оны 10 дугаар сарын 17-ны 16:00 цагт Бөөрөлжүүт цахилгаан станцын төслийн 2-р блокын Турбиныг 3000мин/эрг дээд хурдаар амжилттай эргүүлж туршив.<br>3. 2025 оны 10 дугаар сарын 18-ны 08:09 цагт Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд залгагдсан.<br>4. 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 28-ны өдөр хүртэл станцын 72 цагийн туршилтыг амжилттай хийж гүйцэтгэн, Улсын комисс ажиллах нөхцөл бүрдэв. | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | 5. 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр "Бөөрөлжүүт цахилгаан станц" төслийн 150МВт-ын хүчин чадалтай 2-р блокын барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс 23 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай ажиллаж дууссан.<br>1-р блок ЦС-ын барилгын ажлын гүйцэтгэл 100%,<br>2-р блокын ЦС-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 99%<br>2-р блокын Барилгын ажил 99%-тай байна.<br>2-р блокын зуухны угсралт 100%<br>2-р блокын турбингенератор угсралт 100%<br>2-р блокын цахилгааны систем 100%<br>3-р блокын зуухны барилга угсралт, яндангийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл хийгдэж байна.<br>"Бөөрөлжүүт цахилгаан станц"-ын бүтээн байгуулалтын төслийн эргэн төлөлтийн тооцоолллыг НЗДТГ-т 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 100 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.<br><br>“НӨУБХОМ ҮЦК” ХХК нь төслийн 3, 4-р блокуудын бүтээн байгуулалтын ажлууд дээр мөн хамтран ажиллахаар АНУ-ын Meridian Universal хөрөнгө оруулалтын | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | банкны төлөөллийг Нийслэлийн засаг даргын 1-р орлогчтой уулзалт зохион байгуулсан. Түүнчлэн Canmore Capital хөрөнгө оруулалтын банкны төлөөлөлд Хөрөнгө оруулалтын танилцуулгыг тавьж холбогдох мэдээллийг өгсөн. Хөрөнгө оруулалтын саналыг судлан үзэж өгөхөөр хүлээгдэж байна. | | |
| 2.2 | 5 дугаар цахилгаан станцыг барьж байгуулах ажилд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих бизнесийг хөгжүүлэх сан", "Эрсдэлийн удирдлагын сан"-гийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх. | Төр хувийн хэвшлийн түншлэл | Ашигт ажиллагаа, хувь | | 15% | V цахилгаан станц болон Улаанбаатар хотод шаардлагатай дулааны станцын талаархи тооцоолол саналуудыг гаргаж, холбогдох байгууллагуудад танилцуулж ажиллаж байна. Төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг "Сан"-аар дамжуулан санхүүжүүлэх загварыг боловсруулж, ХОМК болон Улаанбаатар түншлэл төвийн тус тус ТУЗ-ийн хурлаар танилцуулан дэмжүүлсэн. Цаашид тус төслийн хүрээнд шинэ хөрөнгө оруулалтын сан байгуулж, хамтран ажиллах хэлцэл хийгдэж байна. | 100 | 100 |
| **Зорилт 3.** <u>Орон сууцны хөтөлбөрийн хүрээнд орон сууцны хангамжийг 15 хувиар нэмэгдүүлнэ.</u> Улаанбаатар хотыг хөгжүүлэх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ **<u>/АХ-9.3.3, НХТЖҮЧ 9.6.1, НЗДҮАХ 6.1.7, , НХЖТ-314//НХТ-2.1.14/</u>** | | | | | | | | |
| 3.1 | Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Сангийн яам болон Нийслэлийн засаг даргын тамгын | Төр хувийн хэвшлийн түншлэл | Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл, тоо Төслийг | - | 50 | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан"-д хөрөнгө оруулах тухай 108 дугаар тогтоол, 2025 оны 5 сарын 1-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын А/608 дугаар | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | газрын холбогдох нэгжийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх Улаанбаатар хотын “Төлбөрийн чадварт нийцсэн, ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэлийн салбарын төсөл”-ийг Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-тай хамтран хэрэгжүүлэх | | хэрэгжүүлж эхлэх | | | захирамжийг тус тус үндэслэн “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан”-г үүсгэн байгуулах, ТУЗ-ийн гишүүдийг томилох асуудлыг “НӨУБХОМ ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. УАНС-аас НЗДТГ-аар дамжуулан зээлдүүлэх эх үүсвэрээр Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөн, орлогод нийцсэн ногоон орон сууцны эко хороолол бүтээн байгуулах, нийгмийн дэд бүтцийг цогцоор нь шийдвэрлэх замаар агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд Баянхошуу дэд төв, Шар хад дэд төв төсөлд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. “НӨУБХОМ ҮЦК ХХК” нь нэгж эрх эзэмшигчийн хувьд сангийн ТУЗ-ийг 2025 оны 10, 11-р сард хуралдуулснаас Нийслэл дэх төслийн удирдлагын хорооны гишүүн болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна. | | |
| **Зорилт 4.** Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 4.1 | ОУ-ын стандартад нийцсэн хөрөнгө оруулалтын судалгааны аргачлалтай болох. /Short DUE DILIGENCE | Төр хувийн хэвшлийн түншлэл | Судалгааны аргачлал боловсруулж , батлуулах ажлын | - | 50 | Санхүүгийн дүн шинжилгээ<br>Үндсэн тооцоолол:<br>NPV (Net Present Value)<br>IRR (Internal Rate of Return)<br>Payback Period<br>Break-Even Point | 90 | 85 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | and ALTMAN Z score etc./ | | хэрэгжилтийн хувь | | | Нэмэлт тооцоо:<br>Мега төсөлтэй холбогдуулан эдийн засгийн өгөөжийн судлах аргачлал болох ENPV, EIRR (таамаглалтай, эрсдэлд суурилсан тооцоолол)<br>Sensitivity Analysis (Орлогын, зардлын өөрчлөлтөд мэдрэмж) Scenario Analysis (өндөр/дунд/муу хувилбар) боловсруулж байна.<br>Мөн гарааны бизнесийг дэмжих сан дээр нийгэмд үр өгөөжтэй байгальд ээлтэй технологид суурилсан гарааны бизнесийг дэмжих чиглэлээр тусгайлсан журам боловсруулж байна.<br>Үүний хүрээнд Старт Ап экосистемыг бүрдүүлж гарааны бизнесийн төсөл хөтөлбөрийг салбарын үзүүлэлтээр нь эдийн засагт, нийгэмд нөлөөллийн үр дүнгээр нь зэрэглэх ажлыг эхлүүлж цаашид хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөртөө ашиглахаар зорьж байна. | | |
| 4.2 | Гадаад, дотоод зах зээлд нийслэлийн үнэт цаасыг арилжаанд оруулах. | Төр хувийн хэвшлийн түншлэл | Гадаад бонд гаргах хууль эрх зүйн орчныг судлах, бүрдүүлэх, холбогдох | | 50 | “НӨУБХОМ ҮЦК” ХХК нь Нийслэлийн санхүү, хөрөнгө оруулалтын газар, Засаг даргын нэгдүгээр орлогч болон Нийслэлийн Засаг дарга нартай уулзаж, Нийслэл хот санхүүжилт босгох ажлуудад оролцож, хамтран | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | журмыг боловсруулж батлуулах ажлын хэрэгжилтийн хувь | | | ажиллахаар болсон. 2025 онд Нийслэл гурван дотоод бонд гаргасан.<br>Нийслэлийн хангарьд ордны С байрны барилгын санхүүжилт болон Бөөрөлжүүтийн ЦС-ийн 3, 4-р блокын бүтээн байгуулалтуудад хамтран ажиллахаар төлөвлөн хэлэлцэж байгаа.<br>Гадаад валютаар Үнэт цаас гаргах зорилгоор<br>(i) Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 168 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам"<br>(ii) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-304 дугаар тушаалаар батлагдсан "Валютын своп, форвард хэлцлийн журам"-д судалгаа, дүгнэлтийг хийсэн. Эдгээр эрх зүйн баримт бичгийг харьцуулан судалж, дотоод санхүүгийн шинжилгээ болон Хаан банкны 2026 оны эдийн засгийн төлөв байдлын тайланд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаад байна. Үүнд:<br>(i) ам.доллар төгрөгийн эсрэг 2025 онд 5 орчим хувиар чангарсан нь санхүүгийн шинжилгээгээр баталгаажсан. Үүний улмаас тооцогдож буй 8 хувийн своп хэлцлийн зардал нь | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | эдийн засгийн болон хууль зүйн үндэслэлтэй. Одоогийн мөрдөгдөж буй журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд своп хэлцлийн журамд санал оруулах боломжгүй гэж үзэв. | | |
| 4.4 | ULAANBAATAR INVESTMENT 2025 форум зохион байгуулах. | Төр хувийн хэвшлийн түншлэл | Хөрөнгө оруулалтын форум зохион байгуулах бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь | | 50 | Азийн Үнэт Цаасны Форум (ASF) нь Ази, Номхон далайн бүс нутгийн 20 гаруй улс, бүс нутгийг төлөөлсөн 30 орчим гишүүн байгууллагыг нэгтгэсэн, үнэт цаасны салбарын хамтын ажиллагаа, мэдлэг мэдээлэл солилцоог дэмждэг бие даасан олон улсын платформ юм. ASF нь гишүүн байгууллагуудын хооронд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн чиг хандлага, зохицуулалтын орчин, нийтлэг сонирхлын асуудлуудын талаар хэлэлцэх боломжийг бүрдүүлж, жил бүр ээлжит Ерөнхий Чуулганаа зохион байгуулдаг ба Азийн Үнэт Цаасны Форум (ASF)-ын түүхт 30 дахь Ерөнхий Чуулган 2025 оны 9 дүгээр сарын 10–13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээг Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоотой хамтран зохион байгуулж ажиллаж, үйл ажиллагаануудад оролцож, ХОМК-ийн | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | хувьд гадаад харилцаагаа тэлж ажилласан. | | |
| **Зорилт 5.** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх /Санхүү, хууль эрх зүй, хүний нөөцийн асуудлыг хариуцах, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ./ | | | | | | | | |
| 5.1 | Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 тогтоолын дагуу Компанийн засаглалын кодексийг мөрдөж, сайжруулан ажиллана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 100 | “НӨУБХОМ ҮЦК” ХХК нь Компанийн засаглалын кодескийг мөрдөж, СЗХ-д тогтмол тайлагнаж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн тайлангаар 98% үнэлгээ авсан.<br>Компанийн бүтэц, мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц зохион байгуулалтад Үйл ажиллагаа, комплайнсын газар нь хяналт, шалгалтыг гүйцэтгэж, илтгэх хуудсыг Гүйцэтгэх захирал болон ТУЗ-д танилцуулж ажилласан.<br>Компанийн засаглалын үйл ажиллагааны 3 журам, хөрөнгө итгэмжлэн удирдах 4 гэрээ, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, холбогдох дүрэм, журмын хуулийн үл нийцлийг арилгасан.<br>Компанийн засаглалыг сайжруулах дунд хугацааны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох 7 газраар хянуулж, баталгаажуулсан. | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсантай холбоотойгоор бүтэц, орон тооны саналыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан. Компанийн засаглалын кодексийн 1.5 дах хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн гишүүдэд ур чадвар олгох сургалт болох Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах сургалтад нийт гишүүдийг хамруулсан. | | |
| 5.2 | Архив албан хэрэг хөтлөлтийн төлөвлөгөө гаргаж, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу холбогдох баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэн, архивд шилжүүлж, тайлагнана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Архив албан хэрэг хөтлөлтийн төлөвлөгөө боловсруулан, баримт бичгийн хадгаламжийн нэгж үүсгэн 2024 оны бүх бичиг баримтыг 2025 оны 3 сарын 31-ний дотор архивлан тайлагнасан. Архив албан хэрэг хөтлөлтийн төлөвлөгөө боловсруулан, баримт бичгийн хадгаламжийн нэгж үүсгэн 2024 оны бүх бичиг баримтыг 2025 оны 3 сарын 31-ний дотор архивлан тайлагнасан. 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолын дагуу 2020-2024 оны улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гарган, архивын баримтын бүрдүүлэлтийн судалгаа, баримтын хадгалалт, нөхөн | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | бүдүүлэлт, архивын өрөө стандартын хэрэгжилт, архивын нэгжийн хувийн хэргийн карт, дансны бичилт хийсэн. Мөн Үзлэгт шаардлагатай тайлан, бичиг баримтыг бэлтгэж, үзлэгт оролцох бэлтгэл ханган улсын үзлэгт тайлагнасан. 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архив албан хэрэг хөтлөлтийн жагсаалтыг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 5.3 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан цаг үеийн арга хэмжээнүүдэд идэвхтэй тухай бүр оролцох, хэрэгжилтийг хангана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Тухайлбал: НЗДаргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай" А/354 дүгээр захирамжийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээ,<br>Нийслэлийн хэмжээнд мод тарих ажлыг зохион байгуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах. "НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО" хаврын мод тарих аяны хүрээнд манай байгууллага 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Гүйлс нэртэй мод тарьж оролцсон.<br>2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Нийслэлийн шуурхай хурал 22 | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | удаа зохион байгуулагдсанд Гүйцэтгэх захирал оролцсон.<br>НИТХ-ын Эрх зүйн хорооноос зохион байгуулагдсан 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ННЗ-ны болон НӨБ-уудын хуулийн асуудал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалт, хэлэлцүүлэгт оролцсон. | | |
| 5.4 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | “Шилэн дансны тухай хууль”-ийн дагуу санхүүгийн мэдээллийг тухай бүр бүртгэж, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. | 100 | 100 |
| | Шил ажиллагааны систем shilen.gov.mn нээлттэй мэдээллийн ил тод байдал | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Shilen.gov.mn Шил ажиллагааны системд:<br>1.Чиг үүрэг, үйл ажиллагаа стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.<br>2.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.<br>3.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал. | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | 4.Үзүүлж байгаа мэдээллийн талаар дараах мэдээллийн байнга ил тод, нээлттэй байдал.<br>5.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал.<br>гэсэн 5 бүлгийн нэр төрлийн нийт 87 үзүүлэлтээс Нээлттэй байршуулсан 59, Хамааралгүй 28 нэр төрлийн үзүүлэлтүүдийг шилэн ажиллагааны нээлттэй мэдээллийн ил тод байдлын shilen.gov.mn-д байршуулсан байна. | | |
| 5.5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, ажиллана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | “НӨУБХОМ ҮЦК” ХХК-ийн удирдах болон эрх бүхий албан тушаалтан бүр 2024 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулан АТГ-ын https://meduuleg.iaac.mn/ систем 2025.02.15-ны өдрөөс өмнө баталгаажуулан баталгааны хуудсыг гаргуулан бүртгэлжүүлсэн.<br>Шинээр томилогдсон албан хаагчдын ХАСУМ-ийг тогтмол хянуулан өөрчлөлтүүдийг баталгаажуулан ажиллаж байна. Эрсдэлийн зөвлөлийн хурлын гишүүд хуралд оролцох бүрдээ Ашиг, сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэж Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэн, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилладаг. | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 5.6 | ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулна. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар ээлжит хурлыг 2 удаа зарлан хуралдуулсан байна.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар ээлжит хурлыг 4 удаа зарлан хуралдуулсан байна.<br>1 дүгээр хурлаар:<br>• Нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн сонгон шалгаруулалт<br>• Цалин урамшууллын хорооны сонгон шалгаруулалт<br>• Аудитын хорооны сонгон шалгаруулалт<br>• ТУЗ-ийн НБД-ыг сонгон шалгаруулалт<br>• “НӨУБХОМ ҮЦК” ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга.<br>• Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл танилцуулга:<br>• Компанийн 2025 оны төсөв, хөрөнгийн удирдлагын талаар танилцуулга:<br>• Хөрөнгө оруулалтын сангуудын нэгж эрх эзэмшигчийн тогтоолын шийдвэр гаргуулах.<br>2 дугаар хурлаар:<br>• Аудитын хорооны дүгнэлт | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | • "Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК" ХХК-ийн дүрэм, холбогдох журмын өөрчлөлт: (Дүрмийн өөрчлөлт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Ёс зүйн дүрэм)<br>• Итгэмжлэн удирдаж буй Хөрөнгө оруулалтын сангуудын дүрмийн өөрчлөлт<br>• "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан" үүсгэн байгуулахтай холбоотой: Үүсгэн байгуулах шийдвэр гаргах, Сангийн дүрэм батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлах<br>• Үйл ажиллагааны тэлэлт: (Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж авах.<br>• 2025 оны ТУЗ-ийн ээлжит I хурлаас өгсөн бусад үүрэг даалгаврын танилцуулга: (Хамтын ажиллагаа хөгжүүлж, эх | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | үүсвэр нэмэгдүүлэх боломж, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах авлагын тухай)<br>• Эд хөрөнгө актлах тухай<br>• "НӨУБХОМ ҮЦК" ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг чөлөөлөх, томилох тухай<br>3 дугаар хурлаар:<br>• Аудитын хорооны тайлан<br>• Компанийн III улирлын үйл ажиллагааны тайлан<br>• ТУЗ-ийн II хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар (Хөрөнгө актлах тухай, Тусгай зөвшөөрөл авах тухай)<br>• Стратеги төлөвлөгөө 2025 – 2028<br>• Хөрөнгө оруулалт, санхүү менежментийн зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа (Говь-Алтай аймаг, Сэлэнгэ аймаг)<br>• "Эко – Сити" төслийн тухай (Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээг шинэчлэн байгуулах)<br>• "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан"-ийн үйл ажиллагаа, явцын тайлан | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | • Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн схем<br>4 дүгээр хурлаар:<br>• Шинэчилсэн дүрэмтэй холбогдуулан холбогдох журмуудын шинэчлэлт<br>• Төсвийн тодотгол<br>• Бусад асуудал | | |
| 5.7 | Хуулийн хугацаанд компанийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, тайлагнана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хуулийн хугацаанд компанийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, тайлагнасан. | 100 | 100 |
| 5.8 | Компанийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамруулна. | | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтад 2025 онд нийт 15 ажилтан, ТУЗ-ийн 3 гишүүн хамрагдаж, амжилттай суралцан, үнэмлэх авсан.<br>2025 оны 4 дүгээр сард Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг төрийн худалдан авах ажиллагаанаас зохион байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа , ажил , үйлчилгээ худалдан авах хуулийн хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад 5 ажилтан хамрагдаж 1 ажилтан гэрчилгээ гардан авсан. | 100 | 100 |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | Нийслэлийн архивын газраас 5 дугаар сард зохион байгуулсан Архив,албан хэрэг хөтлөлтийн талаар мэдлэг олгох сургалтад нийт 2 ажилтныг хамруулсан байна.<br>Компанийн хүний нөөцийг чадавхжуулахаар нийт 19 сэдвийн хүрээнд 2025 оны 5 болон 6 дугаар саруудад 10 ажилтан бусад ажилтнуудад хуваарийн дагуу сургалтуудыг орсон. Үүнд:<br>AI, Биржийн бус зах зээлийн туршлага, Ёс зүйн кодекс, Байгал орчин нийгэм засаглалын үндэс, Олон улсын цар хүрээ, Уур амьсгал ба нөөцийн менежмент, Тогтвортой хөгжил ба хүрээлэн буй орчны инновац, MS Excel программын томьёоны хэрэглээ, Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэг олгох сургалт, Комплайнсын талаарх ерөнхий ойлголт, Архивын нэгж хэрхэн үүсгэх талаарх мэдлэг олгох сургалт, Алтны арилжааны талаарх ойлголт, Олон Улсын ХОС-ын үйл ажиллагааны талаарх ойлголт, Байгууллагын эрсдэлийн үйл ажиллагааны талаарх ерөнхий ойлголт, Байгууллагын газар нэгж тус бүр БОНЗ-ыг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?, Байгууллагын БОНЗ-ын | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | стратеги гэр мэт сэдвүүдийн хүрээнд сургалтууд үр дүнтэй явагдсан.<br>"ТУЗ СТРАТЕГИ 101" Шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотой Төрийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ийн гишүүдэд бодлого, стратегийн мэдээлэл өгч Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдан ажиллах талаархи сургалтад "НӨУБХОМ ҮЦК" ХХК-ийн ТУЗ-ийн 9 гишүүн хамрагдсан. Энэхүү сургалт нь дараах сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.<br>• ТУЗ-ийн талаарх ойлголт<br>• ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, хариуцлага<br>• Ашгийн төлөө ба ашгийн бус ТУЗ-ийн ялгаа<br>• Төрлүүд: Зөвлөх, хяналтын, итгэмжлэгдсэн<br>• Засаглал ба Стратеги<br>• Сайн засаглалын зарчмууд<br>• ТУЗ-ийн гишүүдийн хариуцлага, шийдвэр гаргалт<br>• Кейс судалгаа: Муу засаглал<br>• Бодит жишээн дээр дүн шинжилгээ хийх | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | • Алдаа, сургамжийг тодорхойлох<br>• ТУЗ байгуулалтын үе шат<br>• Үүсгэн байгуулах үе шат<br>• Хөрөнгө оруулагч татах<br>• Хараат бус гишүүд, олон талт байдал<br>• Үйл ажиллагаа: Ёс зүйн сонголтын цэг<br>• Хүнд нөхцөлд ТУЗ-ийн шийдвэр гаргах жишээг хамтдаа хэлэлцэх<br>• Кейс судалгаа: Эх хүүхдийн эрүүл мэндийн сан<br>• Амжилттай ТУЗ-ийн бүтэц ба хөгжлийн кейс<br>Төрийн албаны зөвлөл Ёс зүйн хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" Нийслэлийн бүсийн зөвлөгөөнийг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Их Хурлын Ёс зүй дэгийн байнгын хороотой хамтран 2025 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж манай байгууллагаас нийт 4 ажилтан хамрагдаж үзэл бодлоо илэрхийлэн оролцсон. | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | | | |
| 5.9 | Байгууллагын дотоод үйл ажиллагаа болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай дүрэм журмыг боловсруулна. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Байгууллагын дотоод үйл ажиллагаа болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай бүх дүрэм журмыг баталсан. Ёс зүйн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлуулсан. | 100 | 100 |
| 5.10 | Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээллийн технологийн мэргэжлийн үйлчилгээ авна. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Microsoft 365 программын эрхийг авч, нийт албан хаагчдад хандах эрхийг тохируулсан. Microsoft 365 программын нэвтрэх үеийн хоёр талт хамгаалалтыг идэвхжүүлж мэдээллийн аюулгүй байдлыг хангасан. Шинэ хэрэглэгчийн 6 бүртгэл үүсгэж, имэйл болон дотоод системийн эрхийн тохиргоог хийсэн. | 100 | 100 |
| 5.11 | ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны чанарын баталгаажуулалтын Магадлан II аудитад орно | | Баталгаажуулах сертификатын тоо | 1 | 1 | ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны чанарын баталгаажуулалтын Магадлан II аудитад 1-р улиралд орж, Баталгаажуулалтын сертификатаа амжилттай авсан. | 1 | 1 |
| | **Нийт дүн** | | | | | | **99.5** | **99.25** |

*2.5.1.төлөвлөгөөний хэрэгжилт 85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн);*

*2.5.2.төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах);*

*2.5.3.төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон.).*

Хянасан: Б.Аззаяа /ДХЭА-ны ахлах хянан шалгагч/

Боловсруулсан: Л.Цолмонтуяа /ҮАКГ-ын дарга/